



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/593

Хэрлэн сум

“Иргэдийн оролцоот Хэтийн Хэнтэй”
арга хэмжээг сурталчлахад зориулж
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах, нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах, “Иргэдийн оролцоот Хэтийн Хэнтэй” арга хэмжээний биелэлтийг иргэдэд сурталчлах зорилгоор танилцуулга бэлтгэхэд 500,000 (таван зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ